



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/270

Чингис хот

Газар эзэмших эрхийн  
гэрчилгээг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу "Монгол эм импекс концерн" ХХК-ий эзэмшлийн Хэрлэн сумын 1 дүгээр баг /Хэргэн/, Тэмүүжингийн гудамжид байршилтай үйлчилгээний зориулалттай 294 м<sup>2</sup> газрыг "Капитал банк" ХХК-д 9 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. "Капитал банк" ХХК-ий эзэмшил газрын тойм зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг "Капитал банк" ХХК-ий захирал /А.Ариунболд/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбэгдуулан аймгийн Засаг даргын 2014 оны А/270 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010776